



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
С.БҮРЭНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2024. 04.29 № 01/3461

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын Ажлын хэсэг тус аймагт ажиллах явцад Засаг даргын 2013 оны а/11, а/14, а/173 дугаар захирамжаар Монгол Улсын Ерөнхий сайд, Хүн аймгийн хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээрийг дагалдан явсан хүмүүсийн хоол, буудлын төлбөрт 6 138 431 /зургаан сая нэг зуун гучин найман мянга дөрвөн зуун гучин нэг/ төгрөгийг зарцуулсан. Тухайлбал, Эдийн засгийн яамны Инноваци, төр-хувийн хэвшлийн газрын дарга С.Бэхбат, Чөлөөт бүсийн хэлтсийн дарга Т.Чимэгсанаа, Чөлөөт бүсийн хэлтсийн мэргэжилтэн Б.Чинбэлэг, Төрийн нарийн бичгийн даргын туслах Г.Батбилэг нарын буудлын төлбөрт 436 500 /дөрвөн зуун гучин зургаан мянга таван зуу/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны шинжээч Т.Энхтөр, М.Эрдэнэжаргал нарын буудлын төлбөрт 70 000 /далан мянга/, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, ажилтнуудын буудлын төлбөрт 549 000 000 /таван зуун дөчин есөн мянга/ төгрөгийг тус тус зарцуулсан зөрчлүүд илэрсэн байна.

Иймээс Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасныг үндэслэн Нийтийн албан тушаалтнуудын дотоод томилолтын зардалтай холбоотой асуудлаар дараах “Зөвлөмж”-ийг хүргүүлж байна. Үүнд:

1/ Өөрийн харьяалах байгууллагын албан хаагчдаас бусад төрийн албан хаагчдын орон нутагт ажиллах дотоод томилолтын зардлыг байгууллагын төсвийн хөрөнгөөс гаргахгүй байх;

2/ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр төрийн албан хаагчдыг дайлж, цайлах, тэдэнд бэлэг өгөх, аливаа хөнгөлөлттэй болон төлбөргүй үйлчилгээ үзүүлэхгүй байх;

3/ албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээдээс бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлын санал тавьсан тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-9.2.6-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4/ орон нутагт томилолтоор ажиллах явцад байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох, урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдал /шатахууны хомсдолд орох, зам хоног, байрны зардал хүрэлцэхгүй байх г.м/ үүссэнээс бусад үед орон нутгийн төсвөөс нэмэлт зардал гаргахгүй байх;

007068

5/ төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг явдлыг таслан зогсоох, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, зөрчил гаргасан тохиолдолд заавал хариуцлага хүлээлгэдэг байх зэрэг болно.

Хүлээн авч, аймаг, сумдын хэмжээнд холбогдох арга хэмжээ авна уу.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Н.ГАНБОЛД